

“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

**ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН 2026 ОНЫ
1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН**

2026 оны 03 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Захиргаа хүний нөөцийн хэлтэс нь 2026 онд 12 ажилтан, албан хаагчидтай, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөцийн бодлого, ажилтан албан хаагчдын нийгмийн болон сургалт хөгжлийн асуудал, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, таниулах мэдээ мэдээллийг бэлтгэн цахим хуудсанд байршуулах, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг ажлуудыг хариуцаж ажиллалаа.

*Дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй
холбоотой мэдээлэл*

**САР ШИНИЙН БАЯРЫН ӨДРҮҮДЭД ОНЦГОЙ БАЙДЛЫН ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН
БАЙДЛЫГ ХАНГАХ ИРГЭДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНД, ЭД ХӨРӨНГИЙГ ХАМГААЛАХ
“ХАРИУЦЛАГАТАЙ ШУУРХАЙ АЛБА АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙДЫН 2026 ОНЫ 02 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН 01 ДҮГЭЭР АЛБАН
ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

№	Заалт	Хэрэгжилт	Хувь
1	Эрхэлсэн салбар харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хариуцлагатай шуурхай алба”-ыг байгуулж, нэгдсэн удирдлага мэдээллийн урсгалыг зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллахыг засгийн газрын гишүүд аймаг нийслэлийн засаг дарга нарт даалгасугай.	Дээрхи албан даалгаврын хүрээнд сар шинийн баярын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг баталж, 02 дугаар сарын 18-наас 21-ний өдрийг хүртэлх хугацаанд Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баасанбат, Дотоод хяналтын албаны дарга Г.Адьяасүрэн, Хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагааны албаны дарга Б.Их-Амгалан нар хариуцлагатай жижүүрээр ажиллаж, байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, албадын хариуцлагатай жижүүр болон төв диспетчертэй нягт уялдаа холбоотой ажиллан, үүссэн асуудлыг түргэн шуурхай цаг алдалгүй зохицуулж шийдвэрлэх, зохион байгуулах ажил үүргийг хариуцаж, гүйцэтгэлээ. Сар шинийн баярын өдрүүдэд төвлөрсөн хогийн цэгүүдэд галгүй, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд 30 хүний бүрэлдэхүүнтэй 3 техник, Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн Сити 00 тус тус ажиллаж, төвлөрсөн хогийн цэгүүдэд сар шинийн баярын өдрүүдэд нийт 4522 тн хог хаягдал ирсэн байна. Газрын хэмжээнд нийт 73 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, өдөр тутмын ажлын мэдээ мэдээллийг ээлжийн диспетчерүүд нэгтгэж, Шуурхай удирдлага зохицуулалтын төвд өдөрт 2 удаа мэдээлэв.	100

**“АЖИЛ АМРАЛТЫН ЦАГИЙГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
2026 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН 22 ДУГААР
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

№	Заалт	Хэрэгжилт	Хувь
1	Ажилтны ажил, амралтын өдрийг энэ	Дээрхи албан тогтоолын хүрээнд Монгол үндэстний уламжлалт баяр-Цагаан сарын битүүний өдрөөр	100

	тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу зохицуулахыг төрийн бусад болон хувийн хэвшлийн байгууллагын удирдлагад уриалсугай.	иргэдийн ажил, амралтыг зохицуулах зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 17-ны Мягмар гаригийн ажлын өдрийг 2026 оны 02 дугаар сарын 28-ны Бямба гаригийн амралтын өдөрт шилжүүлсэнтэй холбогдуулан тус газрын үндсэн чиг үүргийн ажил: - нийтийн эзэмшлийн гудамж талбайн 22 км замын цэвэрлэгээ - төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагаа - хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн сити тойлет - авто баазын 32 машин техник хэвийн үйл ажиллаж, нийт 141 ажилтан албан хаагч ажил үүргээ гүйцэтгэлээ.	
--	--	--	--

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс тус газрын чиг үүрэгтэй хамаарал бүхий 1 удаагийн 1 үүрэг даалгавар, Ерөнхий менежерийн шуурхай зөвлөгөөнөөс газрын чиг үүрэгтэй хамаарал бүхий 5 удаагийн 10 үүрэг даалгавар өгөгдсөний дагуу хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.

Хүний нөөцийн мэдээлэл:

Шилжилт хөдөлгөөний судалгаа

№	Нэр	Шалтгаан	Хүний тоо
1	Ажилд орсон	шинээр	20
2	Ажлаас гарсан	тэтгэвэрт	1
		өөрийн хүсэлтээр	7
	Ажлаас гарсан	нийт	8
3	Шилжсэн		2
4	Сахилгын шийтгэл		5
5	Тэтгэмж авсан		6
6	Хүүхэд асрах чөлөө		3
7	Групптэй		9
8	Чөлөө олголт	ар гэрийн асаргаа	8
		эцгийн чөлөө	1
		төрсөн аав ээж хамаатан нас барсан	3
	Чөлөө олголт	нийт	12

Газрын даргын А тушаал 37, Б тушаал 86 гарч, тайлант хугацаанд ирсэн бичиг 156, явуулсан бичиг 163 байгаагаас ирсэн бичгийн шийдвэрэлтийн хугацаа 97,7 хувьтай байна.



Гэрээ:

Тайлант хугацаанд иргэн аж ахуй нэгжүүдтэй Иргэн аж ахуй нэгжүүдтэй хог хаягдлын гэрээ-54, Худалдах худалдан авах - 6, ажил гүйцэтгэх-17, хамтран ажиллах гэрээ-1, хөлсөөр ажиллах гэрээ-2 нийт 77 гэрээ боловсруулж баталгаажуулж, нийт 21 гэрээ дүгнэв.

Нийгмийн асуудлын чиглэлээр:

Тус газрын сургалт, нийгмийн баталгааг хангах 2026 оны төлөвлөгөөнд тусгасан ажлуудаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Shilen.gov.mn мэдээллийн нэгдсэн системд мэдээ мэдээлэл оруулж байршуулах тухай ажлын хэсгийг газрын даргын 2026 оны А/34 тоот тушаалаар байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч, 6 ажилтан, албан хаагчдад буцалтгүй тусламж үзүүлэв.

- Сургалтын төлөвлөгөөнд тусгасан ажлуудын хэрэгжилтийг ханган:

- Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтыг Нийслэлийн архивын газраас авч, дээрхи сургалтад 20 ажилтан хаагч хамрагдав.

- Эдийн засагч А.Хишигзул Компанийн засаглалын бодлого буюу ТУЗ-ийн нарийн бичгийн танхимийн 2 өдрийн сургалтад хамрагдаж, сертификат авсан.

- Шинээр ажилд орсон 18 ажилтанд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн анхан шатны сургалтыг зохион байгуулсан.

- Тус газраас өндөр насны тэтгэвэрт гарсан 164 ахмадуудад сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлэв.

Хог хаягдлын бодлогын чиглэлээр:

Хог хаягдлын менежментийг сайжруулах, ангилан ялгалтыг нэмэгдүүлэх, дахин боловсруулах боломжийг өргөжүүлэх, олон улсын туршлагыг нутагшуулах чиглэлээр шат дараатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт байрлах Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр баригдсан хог хаягдал ангилан ялгах үйлдвэрийн гадна талбайд цэвэрлэгээ, тохижилтын ажлыг зохион байгуулж, цас мөсийг бүрэн цэвэрлэн, ил задгай хаягдсан хог хаягдлыг ачих, тээвэрлэх ажлыг гүйцэтгэсэн. Үүний зэрэгцээ үйлдвэрийн орох, гарах зам талбайн хөрсийг тэгшилж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн нь тухайн байгууламжийн үйл ажиллагааг тасралтгүй, аюулгүй явуулахад чухал нөлөө үзүүлсэн.

Хаягдал шилийг дахин боловсруулах ажлын хүрээнд шил бутлах, ангилах, нунтаглах технологийн нарийвчилсан судалгааг хийж, тохиромжтой технологийн хувилбаруудыг тодорхойлсон.

Шагнал:

№	шагналын нэр	шагнуулсан ажилтан
1	Хөдөлмөрийн хүндэт медаль	3
НИЙТ		3



*Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлттэй
холбоотой мэдээлэл*

Нийт 36 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэлээ. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа 4 хоног 14 цаг 48 минут бөгөөд, 30 өргөдлийг бүрэн шийдвэрлэсэн, 6 өргөдөл судлагдаж, 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй
холбоотой мэдээлэл*

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцсан байдал:

Газрын [htg.ub.gov.mn](http://ub.gov.mn) вэбсайтын бүрэн шинэчлэх ажлын хүрээнд “Маркетинси партнерс” ХХК-тай хамтарч ажиллан вэбсайтын загвар дизайн, бүтэц, цэсийг бүрэн шинэчлэн, дотоод админ эрхийг монгол хэл дээр болгосноос гадна 3 хэлээр мэдээ, мэдээллийг байршуулах боломжтой болсон.

Өдөр тутмын болон үйл явдлын мэдээ мэдээллийг 7 хоногт 8-10 удаа ил тод байршуулж олон нийтэд мэдээлж түгээхээс гадна Ub west-admin хот нийтийн аж ахуйн салбарын нэгдсэн групп, Хот тохижилтын газар албан ёсны бүх ажилчдын нэгдсэн групп, Нийслэлийн хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын цахим хуудсуудад өдөр бүр 10-12 удаа мэдээлэл оруулахаас гадна фото постерыг цахим сувгуудаар сар тутам шинэчлэн олон нийтэд мэдээлж, байгууллагын албан ёсны пэйж хуудсаар дамжуулан мэдээ бэлтгэн иргэдэд түгээж ажиллалаа.

ХЯНАЖ ТАНИЛЦСАН:
ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.БААСАНБАТ

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД АЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Н.БАЙГАЛЬ